

“Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийн 2007 оны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2008.05.08

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Сайдын зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж шийдвэр гаргуулах.

Хоёр. Хяналт шинжилгээ үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тогтоолоор батлагдсан “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг боловсруулсан болно.

Хөтөлбөрийн 2007 оны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ дараах аргуудыг ашиглав.

- Тайланг уншиж дүн шинжилгээ хийх
- Статистикийн аргаар дүн шинжилгээ хийх
- Газар дээр нь очиж танилцах /2007 онд Архангай аймгийн 3 сум, Булган аймгийн 3 сум, Төв аймгийн 3 сум, Сэлэнгэ аймгийн 8 сум, нийт 17 суманд очиж ажилласан/
- Хэрэгжилтийг зохион байгуулагчид /Мал эмнэлгийн газрын мэргэжилтнүүд, аймгийн мал эмнэлгийн албаны удирдлага, мэргэжилтнүүд/ - тай ганцаарчилсан ярилцлага хийх
- Хэрэгжүүлэгчид /Мал эмнэлгийн анхан шатны нэгжийн малын эмч нар/ - тэй бүлгийн ярилцлага хийх, тодорхой сэдвээр хэлэлцүүлэг хийх
- Хөтөлбөрийн хэрэгжилтэнд оролцогчидтой ярилцлага хийх
- Хөтөлбөрийн үр дүнг хүртэгчдээс асуумжаар судалгаа авах

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

“Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр” нь Засгийн газрын 1999 оны 64 дүгээр тогтоолоор батлагдан хэрэгжиж эхэлсэн ба 2000 онд 1 дүгээр үе шат, 2005 онд 2 дугаар үе шат дуусаж одоо 3 дугаар үе шатандаа хэрэгжиж байна. Хөтөлбөр 2010 оныг дуустал үргэлжилнэ.

Уг үндэсний хөтөлбөрт “Мал сүрэг, аж ахуйн зориулалтаар үржүүлж буй амьтдын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх үндсэн дээр Монгол орон Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын “А” ангиллын гоц халдварт өвчнүүдээс тайван байгааг хадгалан бататгах, нийгэм, эдийн засгийн үлэмж хохирол учруулдаг халдварт, паразитгах өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж мал, амьтны өвчлөл, халдварын хэмжээг аюулгүй түвшинд хүргэх, улмаар Монгол улсын экспортын боломжийг нэмэгдүүлэх” зорилгыг тавьсан бөгөөд энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд 6 багц зорилт дэвшүүлэн тавьсан байна.

“Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2006 оны эцэс хүртэлх хугацаанд 38816.1 сая төгрөгний санхүүжилт хийсэн бөгөөд

2007 онд улсын төсөв болон засгийн газрын нөөц хөрөнгөөс **5764916.0** мянган төгрөгний санхүүжилт олгохоор төлөвлөснөөс **5337513.9** мянган төгрөгний санхүүжилт хийжээ.

Зорилт 1.	2007 онд хийж гүйцэтгэсэн ажлууд
<p>Хилийн мал эмнэлгийн хорио цээрийн найдвартай хамгаалалт бий болгож, мал, амьтны халдварт өвчин, ялангуяа гоц халдварт өвчин улсын нэвтрэхээс сэргийлэх</p>	<p>- 2007 онд БНХАУ, ОХУ зэрэг хил залгаа улсуудад Ази-1 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхийн халдвар гарсан тухай Олон улсын мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас мэдээлсэн. Гоц халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх зорилгоор БНЭУ-д үйлдвэрлэсэн 2.0 сая тун вакциныг нээлттэй тендер зарлан /нэг тунг 449.64 төгрөг/ бүгд 899.2 сая төгрөгт багтаан худалдан авч шүлхий өвчин гарч байсан болон гарч болзошгүй эрсдэл бүхий аймаг, хотын нийт 65 сум, дүүргийн 3.5 сая малыг шүлхийн вирусын А, О, Ази-1 хэвшлийн гурван цэнт вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулав.</p> <p>- Сүүлийн 30-аад жилд тайван байсан хонины цэцэг өвчин 2006 оны 12 дугаар сард гарч нийт 4 аймаг, нийслэлийн 14 сум, дүүрэгт 28 голомт үүсжээ. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай МУЗГ-ын 2007 оны 5 дугаар тогтоол, МУЗГ-аас хөрөнгө гаргах тухай 2007 оны 37 дугаар тогтоол тус тус гарч тухайн өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйн дагуу зохион байгуулан хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоож ажилласан ба МУЗГ-ын 2007 оны 03 дугаар сарын 28 өдрийн хуралдаанаар мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлд тогтоосон хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг татан буулгасан байна. Хонины цэцэг өвчинтэй тэмцэх арга хэмжээний үед ариутгал, халдваргүйтгэлд зориулан 44.9 сая төгрөгийн үнэ бүхий 32.1 тн хлорын шохой, 45.6 сая төгрөгийн үнэ бүхий 292400 ширхэг зүү, 50850 ширхэг тариур тус тус нийлүүлжээ. Мөн 22 аймгийн мал эмнэлгийн албадад халдвар хамгааллын хувцас, хормогч, нүдний шил, маск, гутлаас бүрдсэн 43.4 сая төгрөгний 1224 иж бүрдэлийг олгосон байна.</p> <p>- Хил дамжин халдварладаг өвчинтэй гурван орны хэмжээнд хамтран тэмцэх талаар ОХУ, БНХАУ-ын мал эмнэлгийн албаны эрх бүхий хүмүүсийг оролцуулсан анхны уулзалтыг 2007 оны 8-р сарын 22-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж шүлхий, өндөр хоруу чанартай шувууны томуу, үхрийн болон бог малын мялзан, хөх хэлтэх, үхрийн цээж өвчинтэй тэмцэх, арга зүй, стратегийн талаар тогтмол хамтран ажиллах тухай санал солилцож, туршлагаа хуваалцлаа. Уулзалтаас хил дамжин тархах гоц халдварт өвчин гарсан үед 3 орон 48 цагийн дотор бие биедээ мөн Дэлхийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага /ДХХААБ/, Дэлхийн Мал Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага /ДМАЭМБ/-т шууд мэдээллэх, өвчний голомт үүссэн үед харилцан туслалцаа үзүүлэх, ДМАЭМБ-ын кодод нийцүүлэн амьд мал болон мал амьтны гаралтай бүтээгдэхүүн экспортлох, импортлох үеийн лабораторийн шинжилгээний шаардлагуудыг харилцан зөвшөөрөх, хилийн хууль бус худалдаа болон мал амьтны шилжилт хөдөлгөөнийг таслан зогсоох талаар хамтран ажиллах асуудлуудыг тусгасан зөвлөмж гарсан байна.</p> <p>- Монгол улс, ОХУ-ын мал эмнэлгийн байгууллагуудын хооронд 1994 онд байгуулсан мал, амьтан, тэжээл, түүхий эд бүтээгдэхүүн экспортлох, импортлох дамжин өнгөрүүлэх үеийн мал эмнэлэг, хорио цээр, эрүүл ахуйн чиглэлээр хил орчмын бүсэд хамтран ажиллах тухай хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж Монгол улсын ерөнхий сайдын 2008 оны 04 дүгээр сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэжээ.</p> <p>- Улаанбаатар хотод хуралдсан худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын засгийн газар хоорондын комиссын 10 дугаар хуралдаанаар мал, амьтан харилцан экспортлох үеийн мал эмнэлэг, ариун цэвэр хорио цээрийн нөхцлийг зөвшилцөх, мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн гуравдагч оронд дамжин өнгөрөх үеийн хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийг тохиролцох, шүлхий, хонины цэцэг өвчний улмаас манай улсад тогтоосон хориог цуцлуулах асуудлыг хэлэлцлээ.</p>

Дүн шинжилгээ: Дорнод, Дорноговь, Сүхбаатар аймгийн 30 сумын нийт малаас 359 малыг түүвэрлэн сонгож шинжилгээ хийх замаар 2006 онд тарьсан шүлхийн вакцины дархлааны идэвхийг шалгахад Дорнод аймагт тэмээнд 100%, үхэрт 81.8%, хонь, ямаанд 83.3-87.1%, дунджаар 83.7%, Дорноговь аймагт тэмээнд 71%, үхэрт 85.5%,

хонь, ямаанд 85-96.2%, дунджаар 87.0%, Сүхбаатар аймагт тэмээнд 100%, үхэрт 77.1%, хонь, ямаанд 66-94.4 % дунджаар 79.4%-тай байжээ. Энэ үр дүн дээр тулгуурлан дархлааны хүчдэл харьцангуй өндөр, тогтвортой, удаан сөрөгжиж байна гэсэн дүгнэлт хийлээ.

2007 онд хил залгаа улсуудад шүлхий өвчин гарсан байгаа. Гоц халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн шат шатны байгууллагууд оновчтой хэрэгжүүлсний дүнд 2007 онд манай улсын нутаг дэвсгэрт шүлхий өвчин гараагүй байна.

2006 онд хөрш зэргэлдээх БНХАУ ДМАЭМБ-д гишүүнээр элсээгүй байсан тул хил залгаа бүс нутагт гарсан малын өвчний талаар шуурхай мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байжээ. Үүнтэй холбоотойгоор малын гоц халдварт хонины цэцэг өвчин улсын хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж чадаагүй байна. Гэсэн хэдий ч онош батлагдсан даруйд өвчин тархсан голомтуудад хэрэгжүүлэх арга хэмжээг олон улсын стандартад нийцсэн арга зүйн дагуу зохион байгуулсны үр дүнд халдварыг тухайн голомтонд барьж чадсан байна. Энэ нь халдварт өвчин гарсан үед түүнтэй тэмцэх арга хэмжээг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай болсон гэж дүгнэх үндэслэл болж байна.

Үнэлгээ: Хөтөлбөрийн нэгдүгээр зорилтын хэрэгжилт 90.0 %-ийн үнэлгээтэй байна.

Зорилт 2.	2007 онд хийж гүйцэтгэсэн ажлууд
Мал, амьтны халдварт өвчин илэрсэн, дамжин орж ирсэн нөхцөлд тэдгээртэй тэмцэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх бэлэн байдлыг мал эмнэлгийн албаны бүх шатанд бататгах, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамж, нөөцийг сайжруулах	<p>- ХХААЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 259 тоот тушаалаар томилогдсон тендерийн үнэлгээний хороо Мал эмнэлгийн арга хэмжээг 2007 онд хэрэгжүүлэхэд шаардагдах эм, биобэлдмэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, оношлуур, ариутгалын бэлдмэл худалдан авах тухай нийт 10 тендерийг зарлах, сонгон шалгаруулах ажлыг графикт хугацаанд нь зохион байгуулсан.</p> <p>- Томуугийн А хүрээний Н3N8 дэд хэвшлийн вирусээр үүсгэгдсэн адууны томуу өвчин 2007 оны 10 дугаар сараас эхлэн гарсантай холбогдуулан МУЗГ шуурхай арга хэмжээ авч мал эмнэлгийн арга хэмжээний тендерийн зардлын хэмнэлтээс 492.5 сая төгрөгний, бусад эх үүсвэрээс 350.6 сая төгрөгний санхүүжилт хийхээр шийдвэрлэсэн байна. Адууны томуугаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай 4133 литр буюу 826.5 мянган тун биобэлдмэлийг Биокомбинат ТӨҮГ-г захиалан үйлдвэрлүүлж 22 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн албадад хүргүүлжээ. Мөн адууны томуу өвчин гарсан болон гарч болзошгүй аймгуудад 20 гр-ын хэмжээтэй шприц 50000, тариурын №16 ган зүү 50000, дуслын систем 6000, 10 гр-ын хэмжээтэй шприц 80000, тариурын №16 ган зүү 80000, антибиотик 33600 ширхэг, хуурай глюкоз 5900 кг, кальци хлорид 2600 кг, ариутгалын бодис 32.0 тонныг хуваарилан хүргүүлсэн байна. Үүний зэрэгцээ антибиотик 2000, зүү 6500, 20 мл-ийн шприц 4000, 10 мл-ийн шприц 4000, дуслын систем 150, кальци хлорид 450 кг, хуурай глюкоз 500 кг-г тус тус улсын нөөцөнд авчээ.</p> <p>- Малын паразит өвчнийг эмчлэн сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж 14.4 мянган литр “Абзол-10” бэлдмэлийг 90.0 сая төгрөгөөр, 4983 литр “Авермонмек” бэлдмэлийг 149 сая төгрөгөөр худалдан авч аймгуудын мал эмнэлгийн албадад нийлүүлжээ. Паразитгах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 7.3 сая мал хамруулахаар төлөвлөсөн хэдий ч 19.5 сая мал хамрагдаж 260.7%-ийн гүйцэтгэлтэй биелэсэн байна.</p> <p>- Малын хашаа, байр 5782, малын гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах цэг 332, тоног төхөөрөмж 211 иж бүрдэл нийт 8774.0 мянган квадрат метр талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдэхээр төлөвлөсөн нь 103%-ийн гүйцэтгэлтэйгээр биелэв. Энэ арга хэмжээнд зориулж 200 ширхэг ариутгал халдваргүйтгэлийн төхөөрөмжийг 38.0 сая төгрөгөөр, ариутгалын бэлдмэлийг 141.0 сая төгрөгөөр худалдан авч орон нутгийн мал эмнэлгийн албадад нийлүүлсэн.</p>

Дүн шинжилгээ: Адууны томуу өвчний тархалтыг хязгаарлах талаар мэргэжлийн удирдах болон хэрэгжүүлэх байгууллагууд шаардлагатай бүх арга хэмжээг

авч шуурхай ажилласан хэдий ч 2007 оны 10 дугаар сараас 2008 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд 19 аймгийн 223 сум, 753 багт тархаж 459100 адуу өвчилсэн байна. Томуугаар өвчилсөн адуунаас 428700 адуу эдгэрч, 39 адууг хязгаарлалтанд байлган мал эмнэлгийн байгууллагын хяналтын дор эмчилсэн мэдээтэй байна. 2007 оны жилийн эцсээр тоологдсон 2.239 сая адууны 20.5% нь өвчилж, өвчилсөн 459100 адууны 0.054 хувь буюу 246 адуу хорогдсон байна.

2007 онд 26 нэрийн паразиттах өвчнөөр 7954 удаагийн гаралтаар 552804 мал өвчилсөн байна. Үүнийг 2006 онтой харьцуулахад ойролцоо түвшинд байна.

Өсвөр болон бусад насны 1205.7 мянган үхрийг хамруулан арьсны гуурын үзлэг шинжилгээ хийхэд 70.8 мянган үхэрт өвчин оношлогдож 5.3%-ийн гуурталттай байсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 1.1 %-иар буурсан үзүүлэлттэй байна.

Малын паразит өвчинтэй тэмцэхэд зориулан төрөөс олгож байгаа эм бэлдмэлийн хэмжээ эмчилгээ, урьдчилан сэргийлэлтэнд хамрагдвал зохих малын 60 орчим хувьд хүрэлцэх хэмжээтэй ирдэг гэж орон нутгийн малын эмч нар мэдээллэж байгаа. Нэгэнт бүх малд хүрэлцэх хэмжээтэй эм бэлдмэл ирдэггүй учраас малын эмч нар зах зээл дээрээс тодорхой хэмжээний эм бэлдмэлийг худалдан авах шаардлагатай болдог. Энэ нь малчдад яг адилхан үйлчилгээ үзүүлчихээд нэг хэсгээс нь зөвхөн үйлчилгээний хөлс авах, нөгөө хэсгээс нь эмийн болон үйлчилгээний хөлс авах нөхцөл байдлыг үүсгэж байгаа. Малчдаас судалгаа авахад малын эмч нар бүх малчинд ижил үнэтэй үйлчилгээ хүргэдэг гэж хариулж байна. Малын эмч нар үнэгүй авсан эм бэлдмэлээ худалдаад байна уу, эсвэл өөрөө зах зээл дээрээс худалдаж авсан эм бэлдмэлээ малчдын эрх ашгийн төлөө үнэгүй тараагаад байна уу гэдэг эргэлзээтэй асуудал эндээс гарч ирж байгаа. Малын паразит өвчинтэй тэмцэхэд зориулан төрөөс олгож байгаа эм бэлдмэлийг тойрсон энэ мэт эргэлзээтэй асуудлууд олон бий. Энэ хөрөнгийг мал эмнэлгийн үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг болохуйц зөв механизмаар хүргэх арга замыг олоход удирдах байгууллага болон хэрэгжүүлэх шатанд ажиллаж буй мэргэжилтнүүдийн аль аль нь анхаарах шаардлагатай байна.

Үнэлгээ: Хөтөлбөрийн хоёрдугаар зорилтын хэрэгжилт 75.0 %-ийн үнэлгээтэй байна.

Зорилт 3.	2007 онд хийж гүйцэтгэсэн ажлууд
Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, халдвар судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох, мал эмнэлгийн албыг олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх	Манай улс ДМАЭМБ-ын гишүүнээр 1989 онд элссэн. 2007 онд өөрийн орны мал эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэхээр хүсэлт тавьсны дагуу ДМАЭМБ-ээс OIE /World Organisation for Animal Health/- ийн эксперт Жонис Миллос тэргүүтэй 3 шинжээч Монгол улсад 14 хоногийн хугацаатай ажилласан байна. Тэд Монгол улсын мал эмнэлгийн системийн бүтэц, тогтолцоо, хууль эрх зүйн орчин, мал, малын гаралтай бүтээгдэхүүний импорт, экспортын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо, халдварт, паразит, халдваргүй өвчинтэй тэмцэж байгаа стратеги, хэтийн төлөв байдал, төвийн болон орон нутгийн байгууллагууд, оношлогоо, шинжилгээний лаборатори, хувийн мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаа, боловсон хүчнийг бэлтгэдэг сургалтын хөтөлбөр зэрэгтэй танилцан тодорхой үнэлэлт дүгнэлт өгчээ. Тэдний тайланд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэр гаргагчид, хууль тогтоогчид, мэргэжлийн байгууллагуудад хандсан зөвлөмжүүд багтсан байна. Үхрийн цээж өвчнөөр тайван орны жагсаалтанд орохоор хүсэлт тавьж илгээсэн материалын талаар OIE-ийн шинжлэх ухаан техникийн газрын амьтны өвчний статус хариуцсан мэргэжилтэн доктор Lea Knopf болон доктор Vincenzo Carogale нартай уулзалт хийж зөвлөлдөв. Тэд Мах комбинатаас бүрдүүлэх судалгааны материал хангалтгүй байна гэсэн зөвлөмжийг өгсөн тул энэ асуудлыг түр хойшлуулаад байна. Ирэх жил энэ асуудлыг дэвшүүлэх бүрэн боломжтой болсон байгаа.

Дүн шинжилгээ: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний ариун цэврийн магадлан шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох, хяналт тавих нэгжүүдийн чадавхийг сайжруулах асуудлын

хүрээнд өмнөх онуудад хийгдэж эхэлсэн ажлуудаас энэхүү тайлангийн хугацаанд тодорхой ахиц гараагүй байна.

Орон нутгийн мал эмнэлэг үржлийн нэгж /МЭҮН/-үүдэд мал аж ахуйн бүтээгдэхүүний чанар, ариун цэврийн ерөнхий шинжилгээнүүдийг хийх материаллаг нөхцөл боломж бүрдээгүй байгаа нь мал аж ахуйн бүтээгдэхүүнд гарал үүслийн баталгаа олгох эрхээ бүрэн хэрэгжүүлэхэд тулгарч байгаа гол бэрхшээл болж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, халдвар судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний арга зүйг боловсронгуй болгох чиглэлээр, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, улсын хэмжээний томоохон лабораториудын чадавхийг сайжруулах, тэнд ажиллах боловсон хүчнийг сургаж дадлагажуулах талаар багагүй зүйл хийгджээ.

Мал эмнэлгийн албыг олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэхэд анхаарлаа хандуулж ажилласан нь зохих үр дүнгээ өгсөн байна.

Үнэлгээ: Хөтөлбөрийн гуравдугаар зорилтын хэрэгжилт 75.0 %-ийн үнэлгээтэй байна.

Зорилт 4.	2007 онд хийж гүйцэтгэсэн ажлууд
<p>Мал эмнэлгийн үйлчилгээг хувийн хэвшлийн нэгжүүдээр гүйцэтгүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, энэ чиглэлийн нэгжүүдийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг оруулж, сайдын зөвлөлийн болон Монгол улсын Засгийн газрын хуралдаанаар хоёр удаа хэлэлцүүлэн дэмжүүлж УИХ-д оруулсан. Энэ хуулийн төсөл 2007 оны 11-р сарын 15-ны өдрийн чуулганаар хэлэлцэгдэн батлагдсан байгаа. Одоо хууль сурталчлах, аймгуудад мал эмнэлгийн албадын бие даасан байдлыг хангах талаар удирдамж боловсруулах ажлууд хийгдэж байна. - Малын эмч нарт итгэмжлэл олгох 2 дахь үе шатны сургалтыг зохион байгуулах ажлыг ХХААЯ, МонМЭХ, МЭБС, УМЭАЦТЛ зэрэг мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгуулж эхлээд байна. - Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын эх газрын амьтдын “Эрүүл мэндийн кодекс 2007” номыг орчуулж, хэвлүүлэх, “Малын эмийн үндэсний фармакопей” боловсруулж хэвлүүлэх ажлыг зохион байгуулав. - ХХАА-н салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулах үеэр аймаг, нийслэлийн МЭА-ны дарга, мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч, халдвартын эмч мэргэжилтэн, МЭЭШХ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, МонМЭХ, мал эмнэлгийн газрын мэргэжилтэн нийт 85 хүнийг оролцуулан мал эмнэлгийн салбарын удирдах ажилтны төрөлжсөн семинарыг ХААИС-ийн эрдмийн зөвлөлийн зааланд зохион байгуулав. - “Францын хил хязгааргүй малын эмч нар” төслийн хүрээнд төвийн бүсийн сургалт семинарыг Цэцэрлэг хотод зохион байгуулахад 4 аймгийн мал эмнэлгийн албадын дарга, мэргэжилтэн, сумдын мал эмнэлгийн эмч, малчин бүгд 64 хүн оролцлоо. - “Төвийн бүсийн мал эмнэлгийн тулгамдсан асуудлууд” сэдэвт онол, үйлдвэрлэлийн бага хурлыг Төв аймагт, “Говийн бүсийн мал эмнэлгийн тулгамдсан асуудлууд” сэдэвт онол, үйлдвэрлэлийн бага хурлыг Өвөрхангай аймагт тус тус зохион байгуулав. Энэхүү хуралд нийт 300 гаруй эмч, мэргэжилтэн оролцсон. - Тэжээвэр шувууны аж ахуйд өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээ, Мал эмнэлгийн бүртгэл мэдээлэл, Нүүдлийн шувуудын дунд өндөр хоруу чанартай томуугийн H5N1 вирус илэрсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээ, Аюулын эрсдэлийн мэдээлэл YA304-01, TAD-Info программын хэрэглээ зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

Дүн шинжилгээ: Мал эмнэлгийн үйлчилгээг хувийн хэвшлийн нэгжүүдээр гүйцэтгүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар ихээхэн анхаарч ажиллан зохих үр дүнд хүрсэн байна. Харин эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлсэн ажил хангалтгүй байна.

Улсын хэмжээнд 723 хувийн МЭҮН үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээр нэгжүүдэд их эмч 561, бага эмч 723, мал зүйч 133 ажиллаж байна. Нийт мал эмнэлэг

үйлчилгээний нэгжүүдээс 24 (3.3%) нь онц үнэлгээтэй, 326 (45.1%) нь сайн үнэлгээтэй, 368 (50.9%) нь дунд үнэлгээтэй, 5 (0.7%) нь хангалтгүй үнэлгээтэй байна. Хувийн мал эмнэлгүүдээс 149 (20.6%) нь барилгагүй, 80 (11.1%) нь дуудлага, үйлчилгээний унаагүй байгаа нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй МЭҮН-үүдийг бэхжүүлэхэд хөрөнгө оруулалтын томоохон дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

Одоо ажиллаж байгаа нийт малын эмч нарын 44.4 хувь нь эрэгтэй, 55.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны байдлаар нь авч үзвэл 23-33 насны 175 (11.8%), 33-45 насны 580 (39.1%), 45-55 насны 377 (25.4%), 55-60 насны 188 (12.7%), 60-аас дээш насны 164 (11.0%) малын эмч байна. Энэ үзүүлэлт нь үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу боловсон хүчний эзлэх хувь хангалтгүй байгааг нотлон харуулж байна. Мал эмнэлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх анхан шатанд хүний нөөцийн хомсдол буй болохоос урьдчилан сэргийлэхийн тулд шинэ, залуу боловсон хүчнийг хөдөө орон нутаг руу татах оновчтой механизмыг олж нэн даруй хэрэгжүүлж эхлэхэд төрийн дэмжлэг эрэгтэй байна.

Улсын төсвөөс олгож байгаа халдварт, паразитгах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний хөлс орон нутгийн хувийн МЭҮН-ийн нийт орлогын 70-90%-г эзэлдэг юм байна. Ихэнх малын эмч нар улсын төсвөөс олгож буй үйлчилгээний хөлсөөр МЭҮН-ийн орлогоо хязгаарлачихдаг болох нь тогтоогдоод байна. Өөрөөр хэлбэл төсвөөс олгож буй үйлчилгээний хөлс малын эмч нарын зах зээлийн сэтгэлгээний хөгжлийг нь чөдөрлөчихөөд байна гэсэн үг. Тэд аж ахуйн нэгжийн орлогоо нэмэгдүүлэх талаар санаачлага гаргахгүй байна. Аж ахуйн нэгжийг зах зээлийн зүй тогтлоор удирдахад шаардлагатай мэдлэг олгож, материаллаг дэмжлэг үзүүлэх замаар малын эмчийн сэтгэлгээнд эргэлт гаргах нь МЭҮН-ийн хөгжлийн ирээдүйд чиглэсэн чухал ач холбогдолтой ажил болно.

Мал эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн жишиг үнэлгээг аймгийн иргэдийн хурлаас тогтоож хяналт тавьж байгаа одоогийн тогтолцоо нь МЭҮН-ийн хөгжлийг сааруулах бас нэг хүчин зүйл болж байна.

Үнэлгээ: Хөтөлбөрийн дөрөвдүгээр зорилтын хэрэгжилт 70.0 %-ийн үнэлгээтэй байна.

Зорилт 5.	2007 онд хийж гүйцэтгэсэн ажлууд
Мал эмнэлгийн улсын хяналтын тогтолцоог боловсронгуй болгон, бүх шатанд бэхжүүлэх, үйл ажиллагааг нь жигдрүүлэх	- Хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, үйл ажиллагаандаа мөрдөж буй зарим журам, заавруудыг шинэчлэх, шинэ журам боловсруулж хэрэгжүүлэх, асуудлаар 2007 онд тодорхой зүйл хийгдээгүй байна. Харин боловсон хүчнийг чадавхжуулах, нарийн мэргэшүүлж сургах, туршлага солилцуулах талаар зарим ажлуудыг зохион байгуулжээ. - Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ), Дэлхийн хүнс хөдөө аж ахуйн байгууллага (ДХХААБ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-аас албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу оношлогоо, шинжилгээ хийх чадавхитай болгоход анхаарч томоохон хөрөнгө оруулалт хийсэн байна.

Дүн шинжилгээ: Мал эмнэлгийн улсын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох асуудал 2002 оноос эхлэн хийгдэж эхэлсэн бөгөөд үндэсний хөтөлбөрийн 2-р үе шатанд багтаж хэд хэдэн ажлууд хийгджээ. Өнөөгийн байдлаар мал эмнэлгийн үйлчилгээ, мал аж ахуйн бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, худалдах үйл ажиллагаа, малын түүхий эдийн гадаад, дотоод худалдаа зэрэг үйл ажиллагаанд хяналт тавихад 8 төрлийн журам, зааврыг мөрдөн ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын бүтэц, тогтолцоо ойр ойрхон өөрчлөгдөн тогтворжиж чадахгүй байгаа нь энэ салбарын үйл ажиллагааны үр дүнд сөрөгөөр нөлөөлж байна. Мэргэжлийн хяналтыг анхан шатанд хэрэгжүүлдэг түшмэлүүд 16 ажил үүрэг хариуцдаг тухай бэрхшээл тоочдог. Ийнхүү хариуцах ажил үүргийн тоогоор

мэдээ баримт гаргаж өгөх үүрэг даалгавар ирж цаасанд дарагддаг нь үнэхээр дурьдах ёстой бэрхшээл гэж үзэж байна.

Мал эмнэлгийн хяналтыг бүх шатанд хэрэгжүүлэх боловсон хүчнийг чадавхжуулах, нарийн мэргэшүүлж сургах, туршлага солилцуулах талаар зарим ажлууд зохион байгуулсан хэдий ч мал эмнэлгийн улсын хяналтын тогтолцоог боловсронгуй болгон, бүх шатанд бэхжүүлж үйл ажиллагааг нь жигдрүүлэх талаар үр өгөөжтэй ажил хийгдэхгүй байна.

УМЭАЦТЛ-ийг техник тоног төхөөрөмжийн хүчин чадал, хүний нөөцийн чадавхийн хувьд бэхжүүлэх талаар анхаарч дотоодын болон олон улсын байгууллагуудын санхүүжилтээр нэлээдгүй ажлыг хийсэн нь зохих шалгуурыг хангасан үр өгөөжтэй ажил болсон байна.

Үнэлгээ: Хөтөлбөрийн тавдугаар зорилтын хэрэгжилт 60.0 %-ийн үнэлгээтэй байна.

Зорилт 6.	2007 онд хийж гүйцэтгэсэн ажлууд
Нийгэм эдийн засгийн хөгжилд ноцтой хор хохирол учруулдаг халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Үхрийн арьсны гууртай тэмцэх төсөл МУЗГ-ын 2001 оны 09 сарын 19-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдан 2002-2004 онд хэрэгжсэн. - Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх төсөл МУЗГ-ын 2002 оны 11 сарын 06-ны өдрийн 233 дугаар тогтоолоор батлагдан 2003-2007 онд хэрэгжсэн. - Үхэр, хонь, ямааны бруцеллёзтой тэмцэх төслийг МУЗГ-ын 2001 оны 09 сарын 19-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Төслийн хэрэгжих хугацаа: 2000-2010 он - Шувууны томуугийн цар тахалаас сэргийлэх, тэмцэх үндсэн чиглэл МУЗГ-ын 2006 оны 5 сарын 17-ны өдрийн 110 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2007 оны 3 сарын 14-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор тус үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдан хэрэгжиж байна. - Мал эмнэлгийн анхан шатны нэгжийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргэсэн

Дүн шинжилгээ: Хөтөлбөрийг батлахдаа 3-11 жилийн хугацаатай 5 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тэдгээрээс 2 төсөл хангалттай үнэлгээтэйгээр хэрэгжиж дууссаны зэрэгцээ 1 төсөл төлөвлөсний дагуу амжилттай хэрэгжих байна. Мал эмнэлгийн байгууллагын удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх, үйлчилгээг сайжруулах төсөл хэрэгжээгүй хэдий ч Мал эмнэлгийн анхан шатны нэгжийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргэсэн байна. Харин Мал эмнэлгийн биобэлдмэл, эмийн үйлдвэрлэл, түүний хяналтыг хөгжүүлэх төсөл болон Хилийн мал эмнэлгийн хорио цээрийн салбарыг бэхжүүлэх төслийг 3-10 жилийн хугацаатайгаар 1999 оноос хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

Үнэлгээ: Хөтөлбөрийн зургаадугаар зорилтын хэрэгжилт 80.0 %-ийн үнэлгээтэй байна.

Дөрөв. Ерөнхий үнэлгээ.

Зорилт 1.	Зорилт 2.	Зорилт 3.	Зорилт 4.	Зорилт 5.	Зорилт 6.	Дундаж
90.0 %	75.0 %	75.0 %	70.0 %	60.0 %	80.0 %	75.0 %

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг **75.0** хувийн гүйцэтгэлтэй гэж тооцон **3.75** оноогоор “**шаардлага хангаж байна**” гэсэн үнэлгээ өгч байна.

Тав. Дүгнэлт.

1. Хил дамжин халдварладаг өвчинтэй хамтран тэмцэх талаар ОХУ, БНХАУ-ын мал эмнэлгийн албаны эрх бүхий хүмүүсийг оролцуулсан анхны уулзалтыг зохион байгуулсан нь энэ асуудлыг цаашид тогтвортой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа болжээ.

2. Хорио цээрийн бүсүүд байгуулах, өвчтэй малыг устгах, ариутгал халдваргүйтгэл хийх замаар хонины цэцэг өвчний халдварын голомтыг устгах, зэргэлдээх нутгийн малыг урьдчилан сэргийлэлтэнд хамруулах арга хэмжээг цогцолбор байдлаар зохион байгуулан олон улсын стандартад нийцсэн арга зүйн дагуу хэрэгжүүлсний үр дүнд халдварыг голомтод нь барьж чадсан нь энэхүү арга хэмжээг мал эмнэлгийн албаны бүх шатанд үр дүнтэй хэрэгжүүлэх чадавх дээшилж байгааг нотолж байна.

3. 2007 онд БНХАУ, ОХУ зэрэг хил залгаа улсуудад Ази-1 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхийн халдвар гарсан хэдий ч урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг оновчтой зохион байгуулсны үр дүнд манай улс шүлхий өвчнөөр тайван байна.

4. “Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумдын түвшинд зохион байгуулж шат, шатны орон нутгийн удирдлагаас дэмжлэг авах асуудалд мал эмнэлгийн албадын удирдлага мэргэжилтнүүд, малын эмч нар санаачлага муутай хандаж байна.

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж болгосон асуудлуудыг хэрхэн хүлээж авч байгаа талаар тайланд ямарч зүйл тусгагдахгүй байгаагаас гадна зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай зөвлөмжийг ч үйл ажиллагаандаа тусгахгүй байна.

Зургаа. Санал, зөвлөмж.

- Хөтөлбөрийн хүрээнд тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан үндэсний зөвлөлийн хурлаар батлуулж ажиллахыг өмнөх оны үнэлгээгээр зөвлөмж болгосон байгаа. Гэсэн хэдий ч энэ талаар ямар ч ахиц гараагүй байна. Тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргадаггүй, ажлын үр дүнгээ хөтөлбөрийн үндэсний зөвлөлөөр хэлэлцдэггүйтэй холбоотойгоор хөтөлбөрийн тайлан бүтэц, бичлэгийн хувьд шаардлага хангахгүй байна. Энэ нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ихээхэн бэрхшээл учруулж байгааг анхаарах шаардлагатай.
- Мал эмнэлгийн үйлчилгээний үнийг шат дараатайгаар чөлөөлөн төрөөс үзүүлэх дэмжлэгийг оновчтой болгож мал эмнэлэг үржлийн нэгжийг зах зээлийн жаягаар хөгжих боломжийг нээж өгөх талаар тусгайлсан судалгаа хийх хэрэгтэй байна.
- Мал, амьтдаас хүнд халдварлах өвчний талаар малчдыг тодорхой мэдлэгтэй болгох зорилгоор телевиз, радиогоор явуулсан олон удаагийн сурталчилгаанаас шувууны томуугийн чиглэлээр хийсэн сурталчилгаа тэдэнд хамгийн сайн хүрсэн байна. Иймээс бусад сэдвээр малчдад зориулсан мэдээлэл боловсруулахдаа энэ жишигт хүргэхийг анхаарч ажиллах хэрэгтэй.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн:

МХШҮГ-ын мэргэжилтэн:

С.Дивангар

Танилцаж зөвшөөрсөн:

МХШҮГ-ын дарга:

Д.Бат-Эрдэнэ